



## **ХУУРАМЧ МӨНГӨН ТЭМДЭГТИЙН ТУХАЙ**

*Боловсруулсан: МТҮЗГ-ын эдийн засагч С.Бурэнцогт*

2012 оны 10 дугаар сар

## ОРШИЛ

Хуурамч мөнгөн тэмдэгт байх болон түүнтэй тэмцэх явдал мөнгөн тэмдэгт үүссэнтэй зэрэгцэн оршсоор ирсэн байна. Манай эриний өмнөх 600 онд анх Грект алт болон мөнгөн зоос үүсэх үед суурь металлыг цэвэр алт болон мөнгөтэй холих замаар хуурамч зоосыг үйлдэж байсан байна. Юань гүрний үед буюу 13 дугаар зуунд анх цаасан мөнгийг тусгай модны цаасаар хийж, модыг хатуу чанд хамгаалж байсан ба хэрвээ энэхүү модны цаасаар хуурамч мөнгө хийсэн тохиолдолд цаазаар авах шийтгэл оногдуулж байв. АНУ болон Их Британид 17 болон 18 дугаар зуунд хуурамч мөнгөн тэмдэгт хийх явдалтай тэмцэж гэм буруутныг төрийн эсрэг гэмт хэрэгтэн гэж үзэж цаазаар авах ялаар шийтгэж байжээ. Түүхээс үзэхэд улс үндэстнүүд хуурамч мөнгийг дайны зэвсэг болгон өргөн ашиглаж байсан байна. Жишээлбэл өрсөлдөгчийнхөө мөнгөний бодит өртгийг огцом унагаж эдийн засгийн хямруулахын тулд АНУ-ын тусгаар тогтолцын дайнаар Их Британи улс их хэмжээний хуурамч долларыг үйлдвэрлэж Америк тивд нэвтрүүлж байсан бол Америкийн иргэний дайны үед АНУ-ын өмнөд мужуудын холбооны улсын мөнгөн тэмдэгтэй ижил мөнгийг умардууд хийж байсан. Мөн дэлхийн хоёрдугаар дайны үед нацист Герман улс хуурамч фунт стерлинг болон ам. долларыг ихээхэн хэмжээгээр хийж байв.

Орчин үед дэлхий нийтээр шинэ технологи нэвтэрч байгаа болон нийгмийн бүх сувгаар мэдлэгийг тарааж өгөгдлийг хуваалцаж байгаатай холбогдон хуурамч мөнгөн тэмдэгтийг хийх аюул өсч байна. Хуурамч мөнгөн тэмдэгт хийх технологи нь зах зээлийн шаардлага болон техникийн дэвшлийн хурдан өөрчлөлтийг ашиглаж байна.

## I. МОНГОЛ УЛСЫН ХУУРАМЧ МӨНГӨН ТЭМДЭГТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Монгол улсын Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд 9.1 дүгээр зүйлийг 2010 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар шинээр нэмж оруулсан. Энэхүү 9.1 дүгээр зүйл Төв банкны тухай хуульд дараах байдаар байна. Үүнд:

### 9.1 дүгээр зүйл Мөнгөн тэмдэгтийг хуурамчаар үйлдэхтэй тэмцэх

1. Мөнгөн тэмдэгтийн хуурамч эсэхийг Монголбанк тогтооно.
2. Хуурамч мөнгөн тэмдэгтийг Монголбанк устгана.
3. Мөнгөн тэмдэгтийн хуурамч эсэхийг тогтоох, хуурамч буюу хуурамч байж болзошгүй мөнгөн тэмдэгтийн талаархи мэдээллийг хүлээн авах, хуурамч мөнгөн тэмдэгтийг устгахтай холбогдсон журмыг Монголбанк тогтооно гэж заасан байна.

Иймээс “Гүйлгээнээс илэрсэн хуурамч мөнгөн тэмдэгтийг хүргүүлэх, бүртгэх, хадгалах, устгах журам”-ыг Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга, Цагдаагийн Ерөнхий Газрын даргын 2006 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 452//81/483 тоот хамтарсан тушаалаар баталсан бөгөөд цаашид шинэчлэн боловсруулах шаардлагатай болж байна. Энэхүү журмын зорилго нь хуурамч мөнгөн тэмдэгт үйлдэх, борлуулах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх зорилгоор арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо, валют солих цэгүүдийн үйл ажиллагааны явцад гүйлгээнээс илэрсэн хуурамч мөнгөн тэмдэгтийг хүргүүлэх, бүртгэх, хадгалах, устгах, харилцан мэдээ, мэдээлэл солилцож ажлыг зохион байгуулахад оршиж байна.

Энэхүү журмын дагуу өнөөгийн нөхцөл байдалд Монголбанк иргэд, аж ахуйн нэгж болон арилжааны банкнуудаас гүйлгээнээс илэрсэн хуурамч мөнгөн тэмдэгтүүдийг хүлээн авч, мөн өөрийн салбар болон Мөнгөн тэмдэгтийн хэлтсийн тоолох тасагт Монгол төгрөгийн нууцлалыг таньж ялгах өндөр хүчин чадалтай тоолж ялгах машинууд болон тоологч нарын тусламжтайгаар хуурамч дэвсгэртүүдийг илрүүлж бүртгэл явуулан Цагдаагийн Ерөнхий Газар хүргүүлж байна.

Монголбанкинд бүртгэгдэж, цагдаад хүргэгдсэн хуурамч мөнгөн тэмдэгтийн тоо хэмжээ болон үнийн дүнг 2003 оноос 2012 оны 9 дүгээр сарын 30 хүртэлх хугацаанд харуулахад дараах байдалтай байна.

#### **Хүснэгт 1. Хуурамч мөнгөн тэмдэгтийн тоо хэмжээ**

**Монголбанкны бүртгэлээр**

Онууд	500-т	1000-т	5000-т	10000-т	20000-т	ширхэг	Дүн
2003	9	1	5	11		37	140 263
2004	25	2	25	27		106	408 685
2005	1	6	20	25		77	356 629
2006	3	2	138	117		377	1 864 137
2007	8 533	8	101	182	8	9 014	6 777 346
2008	6	178	215	361	68	1 121	6 227 949
2009		45	55	78	47	225	2 040 000
2010	5	26	47	167	259	505	7 113 600
2011	3	14	177	73	418	685	9 990 500
2012.09.30	2	2	105	92	185	386	5 148 000
Нийт	8585	282	783	1041	800	12147	39 296 000



2011 оны эхнээс хойш 685 ширхэг 9,990,500 төгрөгийн мөнгөн дүнтэй хуурамч төгрөг гүйлгээнээс илэрсэн (Хүснэгт 2-ийг үзнэ үү). Үүнээс 20000-тын дэвсгэртийн хэлбэрээр хийгдсэн хуурамч дэвсгэрт нийт хуурамч дэвсгэртийн мөнгөн дүнгийн 83.6 хувийг эзэлж байхад 10000-тын хуурамч дэвсгэрт мөнгөн дүнгийн 7.3 хувь, 500-тын хуурамч дэвсгэрт 0.01 хувийг тус тус эзэлж байна.

#### Хүснэгт 2. Дэвсгэртүүдийн нийт хуурамч төгрөгийн дүнд эзлэх хувь


Д/д	Дэвсгэрт	Тоо ширхэг	Мөнгөн дүн	Нийт хуурамчид эзлэх мөнгөн дүнгийн хувь
1	500 төгрөг	3	1,500	0,01
2	1000 төгрөг	14	14,000	0.1
3	5000 төгрөг	177	885,000	8.9
4	10000 төгрөг	73	730,000	7.3
5	20000 төгрөг	418	8,360,000	<b>83.6</b>
	Бүгд	9,520	9,990,000	100

Харин 2007 онд 9014 ширхэг 6,777,346 төгрөгийн мөнгөн дүнтэй хуурамч төгрөг гүйлгээнээс илэрсэн (Хүснэгт 3-ийг үзнэ үү). Үүнээс 500-тын дэвсгэртийн хэлбэрээр хийгдсэн хуурамч дэвсгэрт нийт хуурамч дэвсгэртийн мөнгөн дүнгийн 63.2 хувийг эзэлж байхад 10000-тын хуурамч дэвсгэрт мөнгөн дүнгийн 26.9 хувь, 5000-тын хуурамч дэвсгэрт 7.5 хувийг тус тус эзэлж байна. Энэ онд хуурамч 500 төгрөгийн мөнгөн зоосыг их хэмжээгээр илрүүлслний улмаас энэхүү дэвсгэртийн хуурамч мөнгөний бүтцэд эзлэх хувь өндөр гарсан байна.

**Хүснэгт 3. 500-т, 5000-т, 10000-тын дэвсгэртийн нийт хуурамч төгрөгийн дүнд эзлэх хувь**

Д/д	Дэвсгэрт	Тоо ширхэг	Мөнгөн дүн	Нийт хуурамчид эзлэх мөнгөн дүнгийн хувь
1	500 төгрөг	8,533	4,266,500	<b>63.2</b>
2	1000 төгрөг	8	8,000	0.1
3	5000 төгрөг	101	505,000	<b>7.5</b>
4	10000 төгрөг	182	1,820,000	<b>26.9</b>
5	20000 төгрөг	8	160,000	2.4
	Бүгд	9,014	6,777,500	100

Иймээс 2007 онд илэрсэн хуурамч 500 төгрөгийн зоосыг тооцохгүйгээр хуурамч мөнгөн дэвсгэртийн ширхэгийн бүтцийн өөрчлөлтийг авч үзвэл сүүлийн 3 жилд 20000-тын хуурамч мөнгөн дэвсгэртийн эзлэх хувь өсөх хандлагатайг доорхи графикаас харж болно. Учир нь 20000-тын дэвсгэрт анх 2006 оноос эхлэн гүйлгээнд орсноос хойш 20000-тын дэвсгэртийг дуурайлган хийж байсан бол нууцлал нь боловсронгуй болж тунгалаг цонх болон гялгар холограммаар нэмэгдсэн 2009 оны 20000-тын дэвсгэртийг дуурайлган хуурамчаар хийх хандлага өсөх хандлагатай байна.



Эдгээр илэрсэн хуурамч мөнгөн тэмдэгтийн 20-иод хувь нь шатахуун түгээх цэг, иргэдийн гар дээрээс илэрсэн бөгөөд үлдсэн нь арилжааны банкуудаас хүргэгдэж ирсэн. Хуурамч мөнгөн тэмдэгтийг голчлон дараах аргаар дуурайлган хийсэн байна (Хүснэгт 4-ийг үзнэ үү).

**Хүснэгт 4. Хуурамчаар хийгдсэн дэвсгэртийг үйлдсэн арга болон жинхэнэ дэвсгэртийн нууцлалыг дуурайсан шинж тэмдгээр нь ангилах нь**

Д/д	Үйлдсэн арга	Тоо ширхэг	Нийт хуурамчид эзлэх хувь
1	Ялтсан утас	89	<b>34.2</b>
2	Усан хээ	61	<b>23.5</b>
3	Нууцлалтай цаас	0	<b>0.0</b>
4	Бусад аргууд	110	<b>42.3</b>
	Бүгд	260	100.0

Илэрсэн хуурамч мөнгөн дэвсгэрт нь хийц загварын хувьд болхи тул иргэд сонор сээрэмжтэй байхад илрүүлэх бүрэн боломжтой.

Мөнгөн тэмдэгтийн гол нууцлалын нэг болох үнэт цаасны нууцлалыг дуурайсан хуурамч дэвсгэрт одоогоор илрээгүй бөгөөд бүгдийг гэрийн нөхцөлд скайнердаж хэвлэсэн байна. Харин ялтсан утас, усан хээг хоёр цаасны дотор зурж наасан байгаа нь нийт хуурамч дэвсгэртэд 34.2 болон 23.5 хувийг тус тус эзэлж байна.

Гадны (Гийзеке Девриент Компани) болон дотоод (Цагдаагийн Ерөнхий Газар)-ын шинжээчдийн дүгнэлтээр бол хуурамч дэвсгэртүүдийг хийц загварын хувьд дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

1. Хуурамч дэвсгэртийн цаас гөлгөр зөөлөн, ихэвчлэн хуучирсан байдалтай.
2. Усанд норгоход будаг нь уусдаг.
3. “Чингис Хааны” дүр бүхий усан хээг хоёр цаасны дотор зурж наасан.
4. Дэвсгэртийн дэвсгэр өнгөний хээ, зураас нь ямар ч товгоргүй.
5. Дэвсгэртийн өнгө тод биш, зургийн дүрс нарийн биш, бүдэг.
6. Дэвсгэртийг гэрлийн эсрэг барихад харагдах нууцлалын нарийхан утсыг “Чингис Хааны” дүр бүхий усан хээтэй хамт байрлуулж наасан. Зарим хуурамч дэвсгэртэд нууцлалын утсыг хийгээгүй.
7. Дэвсгэртийн ар талд тасалдаж харагдах нууцлалын металл утас хийгдээгүй, түүн дээр (MONGOLBANK) гэсэн бичилт харагдахгүй (2002 болон 2003 оны 5000-т, 10000-тын хувьд).
8. Дэвсгэртийн нүүрэн талд мөнгөлөг, металл суурь дээр байрлагдсан соёмбо үсэг харагдахгүй (2003 оны 5000-тын хувьд).
9. Дэвсгэртийн нүүрэн талд мөнгөлөг, металл суурь дээр соёмбо үсэг болон 10000 гэсэн нэрлэсэн үнэ солигдож харагдахгүй (2002 оны 10000-тын хувьд).

10. Шинэ 2009 оны 20000-тын дэвсгэртийн нэмэлт нууцлал тунгалаг цонх болон холограммын дуурайлган хийсэн боловч цонх дээрх МБ гэсэн үсгүүд болон 20000-тын тоо харагдахгүй, гялгар холограммын туузын бичгүүд харагдахгүй зүгээр гялгар мөнгөлөг цаасаар наасан байна.
11. Дэвсгэртийн нүүрэн талын баруун доод буланд морьтон баатрын дүрс гартаа мэдрэгдэхээр товгор биш (2002 болон 2003).

**Дэвсгэртүүдийг гэрийн нөхцөлд скайнердаж энгийн хувилагч машинаар хийсэн бөгөөд хүлээн авсан этгээд сонор сэрэмжтэй байсан тохиолдолд илрүүлэн сэргийлэх боломжтой.**

Монголбанк мөнгөн тэмдэгтийн нууцлалыг байнга сайжруулахын зэрэгцээ, хуурамч дэвсгэрттэй тэмцэх, илрүүлэх ажлыг ЦЕГ-тай хамтран эрчимтэй хэрэгжүүлж, холбогдох этгээдийг илрүүлэн шалгаж байна. Үүний нэг жишээ нь иргэн Т-ийн 2010 оны 5-р сард 100 ширхэг 10000-тын дэвсгэртийг гэрийн нөхцөлд скайнердан хэвлэж, зарж борлуулахыг оролдсон хэргийн шүүхэд Монголбанк нэхэмжлэгчээр оролцож, шүүхийн шийдвэр гарснаар эдгээр 100 ширхэг дэвсгэртийг Монголбанкинд устгуулсан болно.

2007 онд хуурамчаар үйлдэгдсэн дэвсгэртийн дийлэнхи нь 500 төгрөгийн мөнгөн зоос байснаас гадна 1994, 1995 онуудын 5000-т, 10000-тын дэвсгэртүүд<sup>51</sup> хуурамчаар нэлээд илэрсэн байв. 2009-2012 онд гүйлгээн дэх том дэвсгэрт болох 10000 болон 20000-тын тоо ширхэг огцом нэмэгдсэнтэй холбогдон 10000-т болон 20000-тын хуурамч дэвсгэртийн тоо хэмжээ өссөн байна (Хүснэгт 5. Гүйлгээнд яваа мөнгөний тоо ширхэг болон хуурамч мөнгөн тэмдэгтийн хоорондын харьцаа). Мөнгөн дэвсгэртийн нэг сая ширхэгт оногдох хуурамч дэвсгэртийн хэмжээг гаргахдаа хуурамч мөнгөн тэмдэгтийн тоог нийт гүйлгээнд яваа мөнгөний тоонд хуваагаад 1 саяд үржүүлэхэд гарна.

<sup>51</sup> 1994, 1995 онуудын 5000, 10000-тын дэвсгэртүүд хуурамчаар түлхүү хийгдэх болсон нь нууцлалын хувьд бусад дэвсгэртүүдээс тухайлбал 2002, 2003 оны 5000, 10000-таас харьцангуй сүл байгаатай холбоотой.


**Хүснэгт 5. Гүйлгээнд яваа мөнгөний тоо ширхэг болон  
хуурамч мөнгөн тэмдэгтийн хоорондын харьцаа**

Онуд	1000-т	5000-т	10000-т	20000-т	Нийт гүйлгээнд яваа мөнгөний шир	Хуураамч мөнгөний тоо ширхэг	Сая ширхэгт оногдох хуурамч дэвсгэртийн тоо
2003	7481	9715	9105		65603	37	0,5
2004	5255	7016	12420		81125	106	1,3
2005	6381	6324	14848		92557	77	0,8
2006	6977	7602	16202	1616	109294	377	3,4
2007	8683	10392	16589	6539	132417	9 014	68,0
2008	8492	9682	16938	8701	147601	1 121	7,5
2009	9334	7674	12696	15708	143581	225	1,5
2010	11108	9490	15708	14764	171882	505	2,9
2011	13759	18518	29136	22539	262146	685	2,6
Нийт	77470	86413	143642	69867		12147	

**II. ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ХУУРАМЧ МӨНГӨН ТЭМДЭГТИЙН  
БАЙДАЛ**

Монголбанкнаас мэдээлэл хүссэний дагуу мөнгөн тэмдэгт үйлдвэрлэх талаараа дэлхийд тэргүүлэгч компаниудын нэг ХБНГУ-ын Гийзеке Девриент компанийн хийсэн судалгаагаар олон улсын хэмжээнд 1 сая ширхэг дэвсгэртэд оногдох хуурамч мөнгөн тэмдэгтийн түвшинг гаргасныг ирүүлсэн билээ.

Европын Төв банкны мэдээллээр европийн гүйлгээн дэх тоо болон гүйлгээнд яваа 1 сая ширхэг дэвсгэртэд оногдох хуурамч дэвсгэртийн тоог доорхи байдлаар гаргасан байна.



Дээрх графикаас харахад гүйлгээнд яваа европийн тоо өсч байгаа боловч 1 сая ширхэгт оногдох хуурамч дэвсгэртийн тоо дунджаар тогтмол 30 орчим ширхэг байгаа нь гүйлгээнд байгаа нийт хуурамч европийн тоо өсөх хандлагатайг харуулж байна. Харин 1 сая ширхэгт оногдох хуурамч дэвсгэртийн тоо эх газрын Европд дунджаар 50 ширхэг байхад Их Британид хамгийн их үзүүлэлт буюу 1 сая ширхэг дэвсгэртэд 300 ширхэг хуурамч дэвсгэрт оногдож байна. Энэхүү үзүүлэлт 30-аас 50 байх АНУ-тай харьцуулахад Канад улсад 2004, 2005 онуудад гүйлгээнд яваа 1 сая ширхэгт 500 ширхэг болж хамгийн өндөр түвшин болжээ.



## **Хүснэгт 6. Гүйлгээнд илэрсэн хуурамч европийн бүтэц 2010 оны байдлаар (Европын төв банкны мэдээлийн зорилтууд)**

Дэвсгэрт	5 евро	10 евро	20 евро	50 евро	100 евро	200 евро	500 евро
Хувь	0,5%	1,5%	43,0%	36,0%	16,0%	2,5%	0,5%

Дэлхийн бусад орнуудад тухайлбал ХБНГУ-д хуурамч дэвсгэртийн хэмжээ 1 сая ширхэг дэвсгэрт тутамд 53 ширхэг байдаг бөгөөд Канадад дээрх үзүүлэлт хамгийн өндөр буюу 500 ширхэг юм<sup>52</sup>. Харин Монгол Улсад хуурамч төгрөг нь банкнаас гадуурхи эргэлдэж буй 859 тэрбум төгрөгийн мөнгөн тэмдэгтийн дөнгөж 0.0026 хувь байгаа бөгөөд 1 сая ширхэг дэвсгэрт тутамд 2.6 ширхэг байгаа нь хуурамч мөнгөн тэмдэгтийн асуудал ноцтой түвшинд хүрч очоогүйг харуулна. Харин энэхүү үзүүлэлт 2007 онд их хэмжээний хуурамч 500 төгрөгийн зоосон мөнгө илэрсэнтэй холбогдон 1 сая ширхэг дэвсгэр тутамд 68 ширхэг хүрсэн тохиолдол байна. Монгол улсын гүйлгээнд яваа нэг сая ширхэгт илэрсэн хуурамч мөнгөний тоо хэмжээг 2003 оноос 2011 оны хоорондох хугацааг харуулан доорхи байдлаар үзүүлэв.



Монгол улсын урд хойд хоёр хөршийн хуурамч мөнгөний талаарх мэдээлэл интернетийн мэдээллээс авснаар дараах байдалтай байна. Үүнд:


People's Daily Online-аар БНХАУ-ын Синхау агентлагийн 2010 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн мэдээний эх сурвалжаас авч үзэхэд Нийгмийг Аюулаас Хамгаалах Яамны мэдээлснээр 2008 онд эхэлсэн үндэсний хэмжээний компанийт ажлын хүрээнд Хятадын цагдаа 2 тэрбум юаны (294 сая ам. долларын) үнийн дүнтэй хуурамч мөнгөний 7000 тохиолдлыг илрүүлсэн байна. Энэхүү мэдээгээр зөвхөн 2010 оны 1 дүгээр сараас 11 дүгээр сарын хооронд 1.17 тэрбум юаны үнийн дун бүхий хуурамч мөнгөний 3688 тохиолдолд 6000 хүнийг saatujuljээ (Интернетийн мэдээг хавсаргав).

ОХУ-ын Төв банкны мэдээллээс үзэхэд 2010 онд 128700 ширхэг хуурамч рубль илэрснээс 1000-тын рублийн дэвсгэрт 122495 ширхэг буюу нийт хуурамч 95 хувийг эзэлж байна. ОХУын бүс нутгаар авч үзвэл эдгээр хуурамч дэвсгэртийн

<sup>52</sup> Дээрх орнуудын мөнгөн тэмдэгтийг энгийн нүдээр харахад ялгахааргүй, нууцлалын зарим шинж чанаруудыг дуурайлган маш өндөр түвшинд хуурамчаар үйлдсэн байдаг.

57 хувь нь Оросын төв мужуудад оногдож байна (Интернетийн ОХУ-ын төв банкны веб сайтаас авсан мэдээг хавсаргав).

**ОХУ-ын гүйлгээн явваа мөнгөнөөс илэрсэн хуурамч  
мөнгөний тоо 2010 онд**



## ДҮГНЭЛТ

Хуурамчаар үйлдэгдэх нь ихэссэн 5000-т, 10000-т, 20000-тын дэвсгэрт нь дараах эрсдэлд хүргэж байна. Үүнд:

- Хуурамч дэвсгэртийн нэрлэсэн үнэ өндөр тул хүлээн авсан иргэн, байгууллага хохирох аюултай.
- Хуурамч тэмдэгт банкнаас гадуур шатахуун түгээх цэг, иргэд зэргээр дамжин эргэлдэж байгаа тул илрэхгүй удах, иргэд бэлэн мөнгөний гүйлгээ хийх итгэлгүй болох.
- Ижил серийн дугаартай дэвсгэртүүд ихээхэн хувийг эзэлж байгаа нь хуурамч дэвсгэртийг зохион байгуулалттай хийж байж болзошгүй сэжиг төрүүлж байна.
- Монголбанкинд мөнгө тушаагч томоохон банкуудад орчин үеийн мөнгө тоолох, ялгах, хуурамч мөнгө таних найдвартай тоноглолтой болох шаардлагатай байна.
- Одоогоор тусгай технологиор хийгдсэн төгрөгийн мөнгөн дэвсгэрт гүйлгээнээс илрээгүй ба хуурамч мөнгөн тэмдэгт ихэвчлэн канондож

скайнердаж хувилсан байгаа тул мөнгө хүлээн авагч анхааралтай байж энгийн нүдээр таних боломжтой. Иймээс Монголбанк аж ахуйн нэгж, үйлчилгээний байгууллага, иргэдэд анхаарал сэрэмжтэй байх талаар санамж зөвлөлгөөг өгөх ажлаа нэмэгдүүлэх нь зүйтэй байна.

6. Монголбанк мөнгийг тоолоод цаашид гүйлгээнд хуурамч мөнгө гаргахгүй байх талаар онцгой анхаарч байна. Үүний дотор Монголбанк хамгийн орчин үеийн мөнгө тоолох, ялгах, хуурамч мөнгө таних ХБНГУ-ын БПС, Английн Кобра машинуудыг төгрөгийг тоолоходоо ашиглаж байна. Мөн валютыг ХБНГУ-ын өндөр хүчин чадалтай валют тоолох, ялгах, таних Нумерангийг 2011 онд хүлээн авч ашиглаж байна. Эдгээр тоолох машиныг ажиллуулах инженер техникийн ажилтнуудыг энд онд тухайн нийлүүсэн улсын компанийд сургаж дадлагажуулсан билээ.

## **ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭ**

1. Дэвсгэртүүдийн нууцлалыг таниулах ухуулга сурталчилгааг нэмэгдүүлж явуулах.
2. Хуурамч тэмдэгтийг илрүүлэх, сэргийлэх талаар Цагдаагийн Ерөнхий Газартай нягт хамтран ажиллах.
3. Банкууд тоолох тасагтаа мөнгөн тэмдэгтийн жинхэнэ эсэхэд хяналт тавихад найдвартай тоног төхөөрөмжтэй болохыг шаардаж хэрэгжүүлэх.
4. Бэлэн мөнгө хүлээн авдаг үйлчилгээний байгууллагууд хөх тuyaны зэрэг энгийн багаж ашиглах журмыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх эсвэл хэрэглэх нь зүйтэй болохыг зөвлөх.
5. Бэлэн бус төлбөр тооцоог нэмэгдүүлэхэд эдийн засгийн хөшүүргийн арга хэмжээ авах
6. Мөнгөн дэвсгэртийн бүтцийн оновчтой байдлыг хадгалах (Шинээр том дэвсгэрт үйлдвэрлэх асуудалд болгоомжтой хандах).